



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2019 оны 12 сарын 23 өдөр

Дугаар 111

Мандалговь

**Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг. Хулд сумын Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 22,111,468 /хорин хоёр сая нэг зуун арван нэгэн мянга дөрвөн зуун жаран найм/ төгрөгийн балансын үнэтэй, 11,055,734 /арван нэгэн сая тавин таван мянга долоон зуун гучин дөрөв/ төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, 2015 онд ашиглалтанд орсон 64-16 ДУА улсын дугаартай УАЗ Патриот маркын автомашиныг “Дундговь-Ус” Орон нутгийн өмчит үйлдвэрийн газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

Хоёр. Хулд сумын Засаг даргын тамгын газрын дарга С.Сүхдорж, “Дундговь-Ус” Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын захирал Д.Ганбаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай. Үүнд:

- 2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллага болон сумын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;
- 2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;
- 2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

Гурав. Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.СҮХБААТАР